

3x3  
*Royal*  
lounge



**ОЛИМПЫН ТАЕКВОНДОГИЙН  
УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН**

**2024.11.4-6**

## УДИРДАМЖ

### ОЛИМПЫН ТАЕКВОНДОГИЙН 3x3 БАГИЙН ТУЛААНЫ УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН 2024

#### 1. ЗОХИОН БАЙГУУЛАГЧ: МОНГОЛЫН ТАЕКВОНДОГИЙН ХОЛБОО

ХАЯГ:	Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Спортын төв ордон
УТАС:	(976) 7015-5500
ИМЭЙЛ:	mongoliatekwondo@gmail.com
ВЭБ:	<a href="http://www.mongol-taekwondo.com">www.mongol-taekwondo.com</a>

#### 2. ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО:

ХАЯГ:	Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Спортын төв ордон
УТАС:	(976) 8619-0073
СОШИАЛ:	<a href="https://www.facebook.com/БичигХэрэг">https://www.facebook.com/БичигХэрэг</a>
ВЭБ:	<a href="https://www.facebook.com/MongolTaekwondo">https://www.facebook.com/MongolTaekwondo</a>

#### 3. БАЙРШИЛ: UB Palace, 3x3 Royal Hall Баянгол дүүрэг, 6-р хороо

#### 4. ОГНОО: 2024 оны 11 сарын 4, 5, 6

#### 5. ШААРДЛАГА:

Тэмцээнд оролцогч **Тамирчдад** Монголын таеквондогийн холбооны дүрэм, журмын дагуу дараах шаадлага тавигдана.

ШААРДЛАГА 1:	Оролцогч тамирчин нь Монголын таеквондогийн холбоо болон Күккивоны ямар нэг зэрэг, дантай байна. /жич: Тэмцээн бүсний ангилалгүй зохион байгуулгана/
ШААРДЛАГА 2:	Тамирчин нь Монголын таеквондогийн холбооны цахим бүртгэлийн системд бүргүүлсэн байх шаардлагатай байх ба хүчинтэй лицензтэй байна.
ШААРДЛАГА 3:	Тамирчид шилбэ, шуу, шүд /өнгөгүй тунгалаг эсвэл цагаан өнгөтэй/, эмзэг эрхтний хамгаалалт болон KrNr цахим мэдрэгчтэй оймсыг бэлдэж ирэх шаардлагатай.

#### **Багт тавигдах шаардлага:**

ШААРДЛАГА 1:	Тэмцээнд оролцох байгууллага нь монголын таеквондогийн холбооны албан ёсны гишүүн байгууллага байх ба тухайн байгууллага нь холбоонд татвар, хураамжийн үлдэгдэл тооцоогүй байх.
ШААРДЛАГА 2:	Багууд өөрийн сургалтын төвийн нэр дээр эсвэл ивээн тэтгэгчийн байгууллагын нэр дээрээс тэмцээнд оролцоно.

## Дасгалжуулагч

ШААРДЛАГА 1:	Монголын тасквондгийн холбооны дасгалжуулагчийн В зэрэгтэй эсвэл олон улсын дасгалжуулагчийн эрх бүхий дасгалжуулагч баг удирдах, дэвжээнд авч гарах эрхтэй.
ШААРДЛАГА 2:	Хагас шигшээ болон шигшээ тулааны үеэр дасгалжуулагчид албаны хувцас /костюм/ өмсөх шаардлагатай
ШААРДЛАГА 3:	Тэмцээнд оролцохоор хүрэлцэн ирэх, буцах замд болон тэмцээний үеэр хариуцсан тамирчдынхаа аюулгүй байдалд хяналт тавих нь тухайн багийн дасгалжуулагчийн үүрэг.
ШААРДЛАГА 4:	Тэмцээний үеэр дасгалжуулагч нь ямар ч төрлийн малгай өмсөхийг хориглоно.

## 6. НАСНЫ АНГИЛАЛ БА НИЙЛБЭР ЖИН /4 ТАМИРЧИН/

Нас	Эрэгтэй баг /нийлбэр жин/	Эмэгтэй баг /нийлбэр жин/
Бага нас /8-9 нас/	124кг	120кг
Бага нас /10-11 нас/	150кг	146кг
Өсвөр үе /12-14 нас/	217кг	197кг
Залуучууд /15-17 нас/	266кг	240кг
Насанд хүрэгч /18-29 нас/	307кг	261кг
Мастер /+30 нас/	337кг	283кг

- 6.1 Ерөнхий жинг тэмцээн эхлэхээс хоёр хоногийн өмнө үзнэ.
- 6.2 Сэлгээний тамирчин жин үзүүлэх шаардлагатай ба тухайн багийн нийлбэр жин нь заасан жингийн хязгаарт багтсан байх шаардлагатай.

## 7. ТЭМЦЭЭНИЙ ДҮРЭМ:

Багийн тулааны тэмцээн КрNр цахим онооны системээр явагдана.

- 7.1 Баг бүр тэмцээнд гарааны 3 тамирчин, 1 сэлгээний тамирчинг томилно. Тамирчдыг 1 (хамгийн хөнгөн) - 4 (хамгийн хүнд) хүртэл дугаарлана.
- 7.2 Тэмцээн нь 3 үе шаттайгаар (1-р үе 3 минут, 2-р үе 3 минут, 3-р үе 3 минут), үе хооронд 1 минутын завсарлагатайгаар явагдана.
- 7.3 1-р шат нь уламжлалт багийн тоглолтын хэлбэрийг үндэслэн тамирчид өөртэй нь ижил дугаар бүхий өрсөлдөгч багийн тамирчинтай таарч тус бүр 1 минут тулалдана. Энд багийн тамирчдын дугаарлалт багаас их хүртэлх дарааллаар буюу хөнгөн жингийн тамирчнаас хүнд жингийн тамирчин хүртэлх дарааллаар явагдана. Багийн тамирчин тус бүрийн авсан онооны нийлбэр нь тухайн багийн оноо болж бүртгэгдэнэ.
- 7.4 2-р үед тухайн хоёр багийн тулаан эхлэхээс өмнө багийн дасгалжуулагчийн ирүүлсэн 3 тамирчны дарааллаар 3 минутын турш тулаан явагдана.
- 7.5 3-р үед 3 минутын туршид багийн дасгалжуулагчийн санал болгосон тамирчнаа ээлжлүүлэн (Tag team) тулалдуулна. Үеийн туршид тамирчдын дараалалаас үл хамааран тухайн багийн

гурван тамирчин /хүн нэг бүр/ хамгийн багадаа нэг удаа тулалдсан байхыг шаардана. Ингэхдээ дараах үндсэн дүрмийг дагана.

- 2-р үеийн төгсгөлд тулалдсан 2 тамирчин 3-р үеийг эхлүүлэн тулалдана.
- Тулааны явцад аливаа тамирчин нь хамгийн багадаа 15 секунд дэвжээн дээр тулалдсаны дараа солигдох эрх нээгдэнэ. Энэхүү хугацааг хоёр булангийн цагчин шүүгчид хариуцна.
- Энэ үед багийн тамирчин тус бүр хамгийн багадаа нэг удаа дэвжээнд гарч тулалдсан байхыг шаардана. Хэрэв заавал тулалдах ёстой 3 тамирчны нэг нь тулалдалгүйгээр үеийг дуусгасан болохыг эсрэг баг нь мэдэгдэж, түүнийг нь шүүгчид хянан үзээд батлагдвал тухайн багийг хожигдсонд тооцно.

7.6 1, 2, 3-р үед нийлбэр оноогоор илүү оноо авсан багийг ялагчаар тодруулна. Хэрэв 3 үеийн дараа оноо тэнцсэн тохиолдолд тамирчин солилцооны зарчмаар дээд тал нь 3 минут тулалдуулна. Ингэхдээ түрүүлж 4 оноо авсан багийг ялагчаар тодруулна.

7.7 Торгуулийн тоонд хязгаар тавигдахгүй.

7.8 Багийн тулаанд онооны илт давуу ялалт гэсэн ойлголт байхгүй.

7.9 Нэг нас, хүйсийн ангилалд найм буюу түүнээс дээш баг өрсөлдөж байгаа бол хэсгийн шатнаас шигшээ тоглолт хүртэл хасагдах системээр явуулна.

7.10 Нэг нас, хүйсийн ангилалд долоо буюу түүнээс цөөн тооны баг оролцсон тохиолдолд хагас шигшээ хүртэл тойргоор өрсөлдөж хагас шигшээ, шигшээ тоглолт хасагдах системээр явагдана.

7.11 Таваас долоон баг оролцож байгаа бол санамсаргүй аргаар хоёр хэсэгт хуваагдана. Хэсэг тус бүрт багтаж буй багууд хоорондоо тойргоор тулалдаж хамгийн өндөр оноо авсан хоёр баг хагас шигшээд шалгарна.

7.12 Хэсгийн шатанд хожсон баг 3 оноо, хожигдсон бол 0 оноо авч бүх тойргийн тоглолтын дараа хамгийн өндөр оноо авсан баг хагас шигшээд шалгарна.

7.13 Хагас шигшээд хамгийн өндөр оноо авсан баг хамгийн бага оноо авсан нөгөө хэсгийн багтай учраа таарна. Оноо тэнцсэн тохиолдолд дараах зарчмыг баримтална:

- Багийн авсан онооноос эсрэг багийн авсан оноог хасаад илүү их оноо цуглуулсан баг
- Хэрэв багуудын оноо тэнцсэн хэвээр байх тохиолдолд торгуулийн тоо багатай багийг ялсанд тооцно
- Хэрэв багуудын оноо тэнцсэн хэвээр байх тохиолдолд тэмцээний ерөнхий шүүгч багийн оноолтыг бүрэн эрхийн хүрээнд шийднэ.

7.14 Баг бүр тулалдахаас гучин (30) минутын өмнө шалгагч шүүгчийн хэсэгт очсон байх үүрэгтэй.

7.15 Баг бүрийн оролцогчдын цээжний хамгаалалтын хэсэгт эрэмбийн тоо бүхий дугаарыг таних зорилгоор байрлуулна. Сэлгээний тамирчинд “4” гэсэн тоо өгнө.

7.16 Баг тус бүрт гурван (3) гарааны тамирчин, нэг (1) сэлгээний тамирчин, хоёр (2) дасгалжуулагч, нэг (1) багийн эмч хамт байж болно.

## **8. СЭЛГЭЭНИЙ ТАМИРЧИН:**

8.1 1-р үеийн дараа багийн гурван (3) тамирчны аль нэгийг нь нэг удаа сольж болно.

8.2 Тэмцээний үеэр багийн тамирчид бэртэл авч хамгийн багадаа гурван тамирчин бүхий бүтэн багаар өрсөлдөх боломжгүй болсон тохиолдолд тухайн багийг хожигдсонд тооцно.

## 9. БАГ БҮРДҮҮЛЭЛТ

- 9.1 Бага нас, өсвөр үе, залуучуудын насны ангилалд аливаа багийг зөвхөн өөрийн сургалтын төвийн харьяалагдах тамирчдаас бүрдүүлнэ.
- 9.2 Насанд хүрэгчид болон мастер ангилалд дээд тал нь хоёр хүртэлх сургалтын төв нэгдэн нэг багийг бүрдүүлж болно. Ингэхдээ дараах зарчмыг баримтална.
- Бүх цаг үед шигшээ багт харьяалагдаж байсан тамирчид хамтдаа нэг баг болж болохгүй.

## 10. БҮРТГЭЛ:

- I. Бүртгэлийн цахимаар хийх ба Монголын таеквондогийн холбооны албан ёсны бүртгэлийн систем болох [www.mongol-taekwondo.com](http://www.mongol-taekwondo.com) хаягаар бүртгүүлнэ.
- II. Бүртгэлийн системд тамирчдын бүртгүүлэхдээ сүүлийн 6 сард авахуулсан цээж зургийг ашиглана.
- III. Оролцогчийн хураамжийг зөвхөн цахимаар шилжүүлнэ.

### Оролцогчийн хураамж хүлээн авах данс:

Банк: Хаан банк

Хүлээн авагч: Монголын Таеквондогийн холбоо

Дансны дугаар: 5431161905

## 11. ОРОЛЦОГЧИЙН ХУРААМЖ, БҮРТГЭЛИЙН ХУГАЦАА:

- I. **Энгийн бүртгэл:** 2024 оны 10 сарын 1-нээс 25-ны 23:59 цаг хүртэл
- Улаанбаатар хотын баг 600.000 (зургаан зуун мянга) төгрөг,
  - Хөдөө орон нутгийн баг:
    - Улаанбаатар хотоос 1000 км дотогш 400.000 (дөрвөн зуун мянган) төгрөг
    - Улаанбаатар хотоос 1000 км гадагш 300.000 (гурван зуун мянган) төгрөг
- II. **Хоцорсон бүртгэл:** 10 сарын 25-ны 23:59 цагаас 10 сарын 28-ны 18:00 цаг хүртэлх бүртгэлд баг тус бүр 50.000₮ (тавин мянган төгрөг) нэмэгдэнэ.
- III. 2024 оны 10 сарын 28-ны 18:00 цагаас хойш ямар ч тохиолдолд бүртгэлд өөрчлөлт оруулахгүй.

## 12. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

Насны ангилал тус бүрд эхний гурван байр эзэлсэн багийн тамирчдыг байр эзлүүлж урамшуулна.

---

1-Р БАЙР:	АЛТАН МЕДАЛЬ, ЦОМ, МӨНГӨН ШАГНАЛ
2-Р БАЙР:	МӨНГӨН МЕДАЛЬ, МӨНГӨН ШАГНАЛ
3-Р БАЙР:	ХҮРЭЛ МЕДАЛЬ, МӨНГӨН ШАГНАЛ

---

### 13. ӨМСГӨЛ

- Монголын таеквондогийн стандартад нийцсэн өмсгөл өмсөн тэмцээнд оролцох шаардлага тавигдах хэдий ч багийн нэр, логог /ивээн тэтгэгчийн/ тулааны өмсгөл болон жигдрэлийн хувцсан дээр хадахыг зөвшөөрнө.
- Тэмцээний өмсгөлийн стандарт
- Багийн тулаан зориулан онцгой өөр өнгөтэй таеквондогийн тэмцээний тобок өмсөхийг зөвшөөрнө.



### 14. БАГИЙН АХЛАГЧДЫН УУЛЗАЛТ БОЛОН СУГАЛАА

- I. Багийн ахлагч нар 10 сарын 31-ний өдөр хуралдана.
- II. Багийн ахлагчдын уулзалтад тэмцээнд оролцох багууд төлөөллөө оролцуулах үүрэгтэй.
- III. Тэмцээний дэлгэрэнгүй хуваарийг багийн ахлагчдын уулзалтаар танилцуулна
- IV. Сугалааг тэмцээн эхлэхийн өмнө <https://www.facebook.com/MongolTaekwondo> олон нийтийн хуудаст байршуулна.